



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41
И-мэйл: letter@moh.gov.mn, http://moh.gov.mn

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА
Б.АЗЖАРГАЛ ТАНАА**

2023.03.31 № 10/1368
танай _____-ны № _____-т

Үнэлгээний дүн хүргүүлэх тухай

Тус яамнаас аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2022 оны гүйцэтгэлд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны 374 дүгээр тогтоол болон Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 тоот тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба дүнг үүгээр хүргүүлж байна.

Үнэлгээний тайланд дурдсан зөвлөмж, дүгнэлтийн дагуу холбогдох чиглэлээр цогц арга хэмжээ авч, хамтран ажиллахыг хүсье.

Хавсралт 8 хуудас

Хувийг: Эрүүл мэндийн газарт



С.ЧИНЗОРИГ

141423604



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 он

**АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**

Нэр: Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газар

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2022 онд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хүрсэн түвшинг тогтоон, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулах, удирдлагыг бодит мэдээлэл, санал зөвлөмжөөр хангахад оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Эрүүл мэндийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам батлах тухай” 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай 374 дүгээр тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Аргачлал, загвар батлах тухай” 100 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам батлах тухай” А/346 дугаар тушаалыг тус тус үндэслэн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэсэн. Үнэлгээг Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/14 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг ажил үүргийн хуваарийн дагуу эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн тайлан, яамны холбогдох газар, хэлтсүүдээс гаргасан мэдээ, мэдээлэл болон Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс ирүүлсэн Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон өвөрмөц үзүүлэлтийн биелэлт, Хэрэглэгчийн үнэлгээний тайланг үндэслэн үнэлгээг гүйцэтгэсэн болно.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээг Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам батлах тухай”

A/346 дугаар тушаалын дагуу дараах 5 үндсэн чиглэлийн хүрээнд гүйцэтгэсэн болно. Үүнд:

1. Тухайн байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт
2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт
3. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт
4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт
5. Хэрэглэгчийн үнэлгээ.

Үнэлгээний нэгдсэн хүснэгт

Үзүүлэлт		Жин	Гүйцэтгэлийн хувь	Үнэлгээний жин
№	1	2	3	4
1	Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	0.20	90.0	18.0
2	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	0.15	67.1	10.1
3	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт	0.30	83.3	25.0
4	Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт	0.15	78.0	11.7
5	Хэрэглэгчийн үнэлгээ	0.20	28.0	5.6
Үнэлгээ			71.0	

Нэг. 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

Эрүүл мэндийн газар нь Эрүүл мэндийн сайдын 2022 оны A/346 дугаар тушаалын Хавсралтад тусгагдсан 3.5 хүснэгтийн дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, тайлагнасан байна. Байгууллагын төлөвлөгөөнд 9 үндсэн зорилтын хүрээнд 85 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 2022 онд 90.0%-ийн гүйцэтгэлтэй ба үнэлгээнд эзлэх хувийн жин 18.0 байна.

Хоёр. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт:

Эрүүл мэндийн газар нь Эрүүл мэндийн сайдын 2022 оны A/346 дугаар тушаалын Хавсралтад тусгагдсан 3.6 хүснэгтийн дагуу хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнасан

байна. Хөтөлбөрийн хэрэгжилт 67.1%-ийн гүйцэтгэлтэй ба үнэлгээнд эзлэх хувийн жин 10.1 байна.

Гурав. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт:

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 5.7 дугаарт заасанчлан Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс ирүүлсэн байгууллагуудын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын биелэлтийг үндэслэн, 3 дугаар хавсралтын 3.8-д заасан аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын шалгуур үзүүлэлтийг улсын болон аймгийн дундажтай харьцуулах байдлаар үнэлгээг гүйцэтгэсэн. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт 83.3%-ийн гүйцэтгэлтэй, үнэлгээнд эзлэх хувийн жин 25.0 байна.

Дөрөв. Мэдээллийн ил тод нээлттэй байдлын хэрэгжилт:

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагуудын ил тод байдлыг илтгэх үзүүлэлтэд өөрчлөлт орсон бөгөөд хуулийн дагуу нэмэгдсэн үзүүлэлтийг 2022 оны жилийн эцсийн байдлаар анх удаа тайлагнасан нь өнгөрсөн онтой харьцуулахад шалгуур үзүүлэлтүүд нэмэгдсэн байна. Байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг:

1. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод байдал
2. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал
3. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдал
4. Үзүүлж байгаа үйлчилгээний ил тод байдал
5. Бусад мэдээллийн ил тод байдал гэсэн 5 үндсэн чиглэлээр хэрэгжилтийг гарган үнэлсэн.

Аймгийн Эрүүл мэндийн газрын ил тод байдлын хэрэгжилт 78.0%-ийн гүйцэтгэлтэй, үнэлгээнд эзлэх хувийн жин 11.7 байна.

Тав. Хэрэглэгчийн үнэлгээ:

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 5.8 дахь хэсэгт салбарын хэмжээнд хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээг Эрүүл мэндийн хөгжлийн төв хариуцсан зохион байгуулж, 5.8.4 дэхь хэсэгт заасанчлан уг үнэлгээний дүнг эрүүл мэндийн байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээнд шууд ашиглахаар тусгагдсан. Журам

шинэчилэгдэн батлагдсантай холбоотой ЭМХТ нь 2022 онд анх удаа салбарын хэмжээнд хэрэглэгчийн үнэлгээг цахим хэлбэрээр зохион байгуулсан. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаарх хэрэглэгчийн сэтгэл ханамж нь тухайн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмж, эмнэлгийн мэргэжилтнүүдийн харилцаа, хандлага гэх мэт эрүүл мэндийн байгууллагатай холбоотой олон хүчин зүйлээс гадна үйлчлүүлэгчийн орлогын түвшин, хандлага, тусламж, үйлчилгээ авах үеийн сэтгэл зүй, өвчний үе шат, эдгэрэл зэрэг хийсвэр хүчин зүйлсийн нөлөө ихтэй байдгаараа бусад салбараас онцлог байдаг.

Үнэлгээг тоон судалгааны аргыг ашиглан, тусгайлан боловсруулсан асуумжаар, тухайн агшинд эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчдээр өөрсдөөр нь бөглүүлэх аргаар явуулсан. Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээний нэгж нь эрүүл мэндийн байгууллагын амбулатори болон стационараар тухайн агшинд үйлчлүүлж байгаа иргэд юм. Амбулаториор үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээний түүврийн тоог тогтоохдоо өмнө жил тухайн эмнэлгийн амбулаториор үйлчлүүлсэн хүний тооноос 1 өдөрт үйлчлүүлсэн хүний тоог тооцоолон гаргаж, эх олонлогоор авсан. Харин хэвтэн эмчлүүлэгчдийг түүврийн тоог тогтооход эмнэлгийн орны тоог эх олонлогоор тооцсон болно.

Үнэлгээнд Дархан-Уул аймагт амбулаториор үйлчлүүлсэн 687 хүн түүврээр хамрагдсан боловч хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгийн хувьд судалгаанд хамрагдсан хэрэглэгчийн тоо түүврийн тоонд хүрэхгүй хэт цөөн буюу түүврийн магадлалыг хангаагүй тул үнэлэх боломжгүй байсан. Тиймээс үнэлгээгээр хэрэглэгчийн сэтгэл ханамж 28.0%-тай үнэлэгдсэн байна. Хэрэглэгчийн үнэлгээг ЭМХТ-өөс 2022 оны 11-12 сард зохион байгуулж авсан ба цаашид ЭМГ, АНЭ-ээс удирдлага арга зүйгээр ханган, ЭМХТ-тэй хамтран хэрэглэгчийн үнэлгээг зохион байгуулж хэвших шаардлагатай.

Дөрөв. Дүгнэлт ба зөвлөмж

Дархан-уул аймгийн Эрүүл мэндийн газар нь 2022 онд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хэрэгжилт 71,0%-ийн гүйцэтгэлтэй “С” буюу “хангалттай” гэж үнэлэгдэв. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 90.0 хувь, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт 83.3 хувьтай хэрэгжсэн нь бусад аймгуудаас хэрэгжилт өндөртэй “сайн” байгаа ч Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт 67.1 хувь байгаа нь “дутагдалтай”, Хэрэглэгчийн үнэлгээ 28.0 хувь байгаа нь “хангалтгүй” байна.

Үнэлгээнд үндэслэн нэгдсэн зөвлөмж:

1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт:
 - Төлөвлөгөөнд зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр бий болох үр дүн, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхой төлөвлөх
 - Шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин нь тухайн жилдээ хэрэгжих боломжтой, тоон ба чанарын утгаар илэрхийлэгдэх, хэмжигдэхүйц, үр дүнг харуулсан байх бөгөөд бодлогын баримт бичиг, статистик тоон мэдээлэл, салбарын мэдээлэлд үндэслэсэн байх
 - Тайлант жилд тухайн асуудлын хүрээнд гарсан өөрчлөлтийг (ахиц, дэвшил, бууралт) тодорхой гаргахын тулд тоон үзүүлэлттэй, харьцуулалт хийх зарчмаар тайлагнах
 - Байгууллага бүр гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээний танилцуулга, дүнг байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, хурлаас гарсан дүгнэлт, зөвлөмжийг иж бүрэн тайлан, хэрэгжилтийн хамт албан бичгээр Эрүүл мэндийн яаманд ирүүлж байх
 - Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын хяналтыг сайжруулах, хагас бүтэн жилийн тайлангийн хэрэгжилтийг удирдлагын түвшинд хэлэлцүүлж хэвших
 - Тайланг хэт нуршуу биш, товч бөгөөд тодорхой, Журмын дагуу хоёр мянган тэмдэгтэд багтааж тайлагнаж хэвших
 - Цаашид аливаа тайлан мэдээг цахим хэлбэрээр ирүүлж хэвших
2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр:
 - Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасанчлан шалгуур үзүүлэлтийн дагуу бүрэн, үнэн зөв, бодитой, тодорхой тайлагнах
 - Тайланд холбогдох мэдээлэл, судалгааг хавсаргаж байх
 - Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг бодитой тайлагнах
 - Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувийг тодорхойлохдоо зөвхөн шагнал, урамшууллын зардлыг нийт төсөвт харьцуулахгүй байх

- Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувийг заавал тайлагнах
 - Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хуулийн дагуу албан хаагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулж хэвших
 - Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөл, ажиллах таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын мөрөөр арга хэмжээ авч ажиллан албан хаагчдыг мэдээллээр хангаж ажиллах
3. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр:
- Монгол Улсын 2021 оны “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах
 - “Төрийн байгууллагын цахим хуудсанд тавигдах шаардлага MNS6285:2017” стандартын дагуу цахим хуудсыг ажиллуулж хэвших
 - Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах талаар төлөвлөгөө боловсруулан ажиллах
 - Тайлагналтыг шалгуур үзүүлэлт бүрийн дагуу товч, тодорхой, холбогдох нотлох баримт, гарсан шийдвэр, бүртгэл, судалгааг хавсралтаар тайлагнах
 - Шилэн дансны тухай хуулийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн зарчмыг баримтлан мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, бүрэн байршуулах
 - Ил тод байдалд тавих дотоод хяналтыг сайжруулах
4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын талаар:
- Эмнэлгүүдийн статистик мэдээллийн албанаас мэдээ тайланг үнэн зөв гаргах, ЭМТҮЧБА-аас эмнэлэгт бүртгэгдсэн өвчлөл, нас баралт, давтан хагалгаа, хагалгааны хүндрэл, түүнд нөлөөлсөн шалтгааныг судалж, удирдлага, мэргэжилтнүүдийг цаг тухай бүр нь мэдээллээр хангаж, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж ажиллах
 - Эмнэлгийн тайлан, мэдээ гаргаж буй эмч мэргэжилтнүүдийн үйл ажиллагаанд эмнэлгүүдийн удирдлага, дотоод хяналтын алба, нэгжээс тогтмол хяналт тавьж ажиллах
 - Эмнэлэгт бүртгэгдсэн нас баралтаас зайлшгүй эмгэг судлалын шинжилгээнд хамрагддаг тохиолдол /11/-уудыг бүрэн хамруулах, эмчилгээ үйлчилгээний дутагдал, хоног болоогүй нас баралт, давтан мэс засал, мэс заслын дараах хүндрэл зэрэг үзүүлэлтүүдийг нэмэгдүүлэхгүй байх тал дээр эмнэлгийн удирдагууд онцгой анхаарч тодорхой ажил зохион байгуулах

- Орон нутагт эх, хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр дараах үйл ажиллагааг хамруулсан, цогц арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх.
Үүнд:
 - Улсын хэмжээнд жирэмсний эрт хяналт ба тогтмол хяналтын үйл ажиллагааг чанаржуулах, аливаа эмгэгийг эрт үед нь илрүүлэх, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авах
 - Өсвөр насны хүүхдүүдэд бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх, жирэмснээс хамгаалах арга хэрэгслийг таниулах, сурталчилах, эрүүл мэндийн боловсрол олгох
 - Эхийн эндэгдэл, нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг тууштай бууруулах арга хэмжээ
 - Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчний илрүүлэг шинжилгээ болон улсын хэмжээнд зохион байгуулж байгаа эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд 18-аас дээш насны хамрагдвал зохих иргэдийг бүрэн хамруулж, өвчлөл илэрсэн тохиолдлыг эмнэлгийн хяналтад авч хяналт тавьж ажиллах
5. Хэрэглэгчийн үнэлгээний талаар:
- Амбулаторийн эмчийн үзлэгийн цагийн болон орны хүлээгдлийг багасгах, эмнэлгийн эм тариа, ороох боох хэрэглэгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх, эмнэлгийн мэргэжилтний үйлчлүүлэгчид эмчилгээний талаар тайлбарлах, үйлчлүүлэгчийг анхааралтайгаар сонсох ур чадварыг нэмэгдүүлэхэд анхаарах
 - Цаашид хэрэглэгчийн үнэлгээний нэгдсэн систем тогтвортой ажиллаж жилийн турш эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг бодитой авах боломж бүрдэж байгаа тул эрүүл мэндийн байгууллагууд үйлчилгээ авсан иргэдийг хэрэглэгчийн үнэлгээнд хамрагдах соёлыг түгээн дэлгэрүүлэхэд санаачлагатай ажиллах
 - Жилийн турш авч байгаа хэрэглэгчийн үнэлгээндээ тогтмол дүн шинжилгээ хийж сэтгэл ханамж хангалтгүй байгаа чиглэлээр эрүүл мэндийн байгууллагууд анхаарч, тусламж, үйлчилгээнийхээ чанарыг тогтмол сайжруулж ажиллах

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР